

СҮҮЛЧИЙН “ХИАД”

Ч.Сосорбарам

Батлан Хамгаалах Яам, sosorb58@yahoo.com

Өгүүллийн товч утга: Түүхчид, судлаачдын дунд “халх” гэсэн нэрийг янз бүрээр тайлбарласаар ирсэнийг нэг мөр болгон халх гэдэг нь хаан төрийн төв отог хэсэг буюу хиадуудыг халхалах үүрэгтэй аймаг, хошуу, түмэдийг нэрлэж байгаад эцэст нь нэг угсаатан болжээ гэсэн орон нутагаа судлах үед төрсөн санаагаа энэхүү өгүүлэлдээ нийтлэлээр гаргаж тавьж байгаа юм. XII, XVI зууны үед аймаг, отог, ястан угсаатангуудыг холилдуулан нэг үндэстэн бүрэлдүүлэх үйл ажиллагааг төрийн хатуу бодлогоор гүйцэлдээсний түүхэн үр дүнд халх, цахарууд бий болжээ. Халх, цахарууд “халхлах хамгаалах” түмэд гэлтэй. Эдгээр 6 түмэн “үйлчлэх, халхлах хамгаалах” зорилготой байсан юм бол “төвийн түмэн, хаа байсан ба түүнийг хэн толгойлж байсан тухай ...” асуулт аргагүй төрөх нь ойлгомжтой. Даян хааны удмынхан буюу боржигин овгийн олон ноёд, язгууртнууд халхын 4 хан болон бүх хошуудад жигд тархаснаар халхыг бүрэлдүүлэгч олон овог, отог угсаатны хувьд ижилсэж ойлтжээ. Ингэснээр гол язгууртнууд төвлөрч байсан хиадууд болон бусад халх хошуудын угсаа, эрх ямба, эдийн засгийн байдал адилхан болсноор хиадын гол язгуурын нутаг хошууны эрх, үүрэг бүдгэрч багасан улмаар “халх” хэмээх орчин үеийн монгол үндэстэнийг бүрдүүлэгч гол угсаатан төрөх үндсэн нөхцөл болжээ дүгнэлтэд хүрч байна. Ингэж “халх” гэсэн үг монголчуудын гол угсаатны жинхэнэ нэр болон хэлбэржин тогтсон бөгөөд Батмөнх Даян хаан, Гэрсэнз, Абтай сайн хаан нарын үүрэг их байжээ. Мөн овог угсаатны нарийвчилсан судалгаагаар монголын язгуур хиад овог¹ нь өнөөдөр зөвхөн Орхон Туулын билчир нутагт байгаа зэрэг нь XIII зуунаас өнөөг хүртэл хиадууд тодорхой газар нутагт оршоор ирснийг харуулж байна. Харин хиад овгийг “овог” гэх үү “овгийн улбаа” эсхүл “яс” гэх үү гэдгийг л судалж тодотгох шаардлага бий. Мөн хиян, хиад, хиягуд, хиа нар гэсэн үгийн үндсийг сайтар харьцуулан судлах нь зүйтэй гэж үздэг.

Түлхүүр үг: хиад яс, боржигин овог, төрд манлайлах үүрэг, улсыг төвхнүүлэх, монголын язгуурын гол овгийнхон, гол сурвалжит овог, олон ястан, угсаатан, Монголын гол орон, аюулгүй байдлыг бэхжүүлэх, монголын өндөрлөгийг гадаад дотоод талаас хамгаалах. Их хүрээ, хаадын өргөө, язгуур хиадуудын/улус иргэд/ аюулгүй байдлыг “дотоодоос халхалах”, суурин иргэд, стратөгийн ач холбогдолтой газар, нүүдэлчид, нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо хамгаалах асуудал, улс үндэстэний аюулгүй байдал, хаан төрийн тогтвортой байдалын амин чухал ач холбогдол бүхий төрийн бодлого.

Монголчуудын ихэнхи нь өөрсдийгөө төв халхууд гэцгээж овог, яс угсаагаа сайн мэддэггүй нь тэд улс, үндэстнийхээ олонхи болж төвд байдаг тул энэ талаар бага анхаардаг, мөн орон нутагт хийсэн судалгаа цөөн байдаг зэрэгтэй холбоотой төдийгүй түүхэн тодорхой хүчин зүйлсын үр дүнд бий болжээ.

Ингээд өөрийн овгийг тогтоох гэж оролдож, нутаг усныхан маань харъяалагддаг Төв халхын төвд байдаг Дэлгэрхаан сумынхны овог, ургийн хэлхээсийг сумынхаа 80 жилийнх нь ойд зориулан судалж байхад халхчууд, хиадуудын талаар төрсөн санал, бодлоо Та бүхэнтэйгээ хуваалцъя.

Түүхчид, судлаачдын дунд “халх гэдэг нь халхавч, халхлах гэсэн үгтэй язгуур нэгтэй” гэсэн байхад “халх” гэсэн овог, угсаа байсан гэх зэргээр янз бүрээр тайлбарласаар ирсэн халх гэдэг нь хаан төрийн төв отог хэсэг буюу хиадуудыг халхлах үүрэгтэй аймаг, хошуу, түмэдийг нэрлэж байгаад эцэст нь нэг угсаатан болжээ гэсэн санаагаа энэхүү нийтлэлээр баталгаажуулах зорилт тавилаа.

• Хүннү, Нирун гүрнүүдын гол сурвалжит овог нь адил буюу хиян нар байжээ.¹ Мөн Рашид-Ад-дин бичихдээ “Алун гоогийн нөхөр Добун баян¹Чингисийн 11-р үеийн овог² хиян овгоос гарсан...”² МЭӨ 200–172 оны үед дайн дажнаас дүрвэсэн Хиян, Наху гэдэг хоёр хүн Эргүн гүн ууланд бүгж аж төрөн сууснаар олон айл өрх болж өсч үржээд тус тус хоёр

¹ Г.Сүхбаатар Монгол Нирун Улс.УБ., 1992, Монгол Улсын Түүх, 2003, УБ, 1–р боть, хуудас 194

² Сборник летописей. т. к №4 д М-Л, 1952 он, 79, 154

овогтой болов. Хианы хойчис нь Хияуд овог болжээ.³ “Хиан” гэдэг нь түргэн догшин хүрхрээ мэт олноос хэтийдсэн бяр чадалтай гэсэн утгатай үг юм. Бөртэ Чинуа бол Хианы хойчис болохоор боржигон овогтон бол Хияд ястан мөн гэдэг.

Ингэж МЭӨ III – МЭ III зууны үед оршиж байсан Хүннү, Сяньби, Тоба-г улс гүрнийг залгамжилсан Нирун улсаас улбаатай хиян-хиад нарын угсаа Добу, Алунгоо хатнаар дамжин үргэлжилсээр Есүхэй баатарын үед хүрчээ. Алтан товч судар болон түүхийн номуудад энэ тухай дурдаад Есүхэй баатарыг хиад ястай, боржигон овгийн хүн гэж бичсэн байдаг. Хиад овог нь монголын язгуурын гол овгуудын эхэнд байж бусад овог, угсааг салбарлуулжээ. Хиадаас гаралтай боржигон, дүрвэд, боржигиноос салбарласан бэсүд, урууд, мангуд, сөнөд, барулас зэрэг олон ураг, овгууд янз бүрийн цаг үед олон төрлийн нөхцөл байдлын дунд үүсч олшрон салбарлаад хиад овог түгээмэл болж мартагдахад хүрч, нэг үе бусад овгуудаас ч ялгархаа байсан гэдэг.

Харин Хабул хааны үеэс төр барьж байсан гол сурвалжтанууд (Тхөвгүүд нь) бусдаас ялгарахын тулд хиад ясаа сэргээж байжээ⁴.

Ер нь “хиад овог” монголын түүхэн тодорхой үеүдэд сэргэн төрд манлайлах үүрэг гүйцэтгэж байжээ. Нирун улс сэргэн мандах, Хабул хаан хүчирхэгжин улмаар Их монгол улсыг төвхнүүлэх, Батмөнх Даян хаан нэгдсэн улсаа сэргээх зэрэг түүхэн цаг үеүүдэд тэд өндийн гарч ирж байв.

• Түүх сөхвөл нүүдэлчдийн “сонгодог-түүхт” Орхон, Туул голын бэлчир нутагт Их хааны хүрээ XIII зууны сүүлчээр төвлөрч нутаглажээ. Ингэж Хан Хэнтийгээ дархалсаны дараахан хааны ойрын сурвалжит удмынхан буюу хиадууд энэхүү Хар хорин хот хавьд нүүн ирснээр монголын язгуурын гол овгийнхон энд суурьшив.

Чингис хаан олон аймаг, овгуудыг нэгтгэж, мянгат, түмтийн шинэ зохион байгуулалтад оруулах үйл ажиллагааг гүйцэлдээж олон ястан, угсаатныг хольж ойртуулсан. Гэхдээ хааны ойрын удмынхан буюу хиадуудад бусад овог, аймгуудын адил тараан хуваарилагдах хувь заяа оногдоогүй нь тодорхой бөгөөд тэднийг “зэргийн 12 мянгад”, “улус иргэн”-ээс бүрдсэн голын түмэн ч гэдэг байжээ. Тэмүжин төр барих болсон үеэс хиадын доторхи жүрхэн зэрэг овгууд хаан ширээний төлөөх тэмцлийн улмаас устаж үгүй болох буюу удирдагчгүй болж бусад хиад нартаа ууссан байдаг.

Чингис хаан гадагш аян дайнд явахдаа отгон дүү Тэмүгэд-Отчигинд нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо /гал голомтоо/ хамгаалах асуудлыг хариуцуулдаг байв. Тэмүжин Их хаан болоод өөрийн ноёд, түшмэд, хүргэн нараа шагнасны дараа ургийнхандаа хандаж “хувь” олгожээ. Хаан хоёр дахь хувь өгөхдөө⁵ тэдгээрийн газар нутгийг тодорхой болгож Тулуйд нэмж түмэн хуяг өгч, Онон, Хэрлэн, Орхон, Туул, Сэлэнгэ тэргүүтэн Монголын гол орныг эзлүүлэв.

Өгөдэйд 4 мянган хуяг өгч, Ил Тарвагатайг Уйгурын газар нутгийн хамт эзлүүлэв, Өгөдэй Хаан болохдоо Хами-гаас ирлээ гэсэн байдаг. Түүний ач хүү Хайдугийн угсааныхан Юань гүрэн унасны дараа ч Ил тарвагайд нутаглаж байв. Зүчид 4 мянган хуяг өгч Сибир, Кипчакийн газар нутгийн хамт эзлүүлэн улс гүрний баруун талын аюулгүй байдлыг бэхжүүлэв, Цагаадайд 4 мянган хуяг өгч Дундат Азийн газар нутгийн хамт эзлүүлэв. Тэд монголыг баруун урд талаас нь хамгаалж байсан бол Хасарт Гаули тэнгисийн Жалайд, хавь ойрын Хинанлин давааны хавь, дүү Хачиуд Зүрчидийн нутгийг гэх мэт зүүн талаас монголын өндөрлөгийг гадаад талаас хамгаалах хувиар хийжээ.

Төр улсаа төвшитгөн товхиноулж дуусаад морин дээрээс буусны дараахан Өгөдэй хаан аймаг, хишигтэн, хэвтүүлийн түмт, мянгатуудаа тайван цагийн байдлаар өөрчлөн зохион байгуулж, Орхон, Туулийн бэлчирт нүүдэллэгч Их хүрээ, хаадын өргөө, язгуур хиадуудын /улус иргэд/ аюулгүй байдлыг “дотоодоос халхлах” Зураг №1а.б зорилгоор Хангай нурууны ард, Хөвсгөл, Хэнтий нурууны хавьд байрлуулжээ. Үүнд Ихирэс /Отчигины захирсан/, жалайр, хонгирад, уруд, мангуд 5 түшээ аймгууд голлов.⁶

³ Монголын түүхийн толь р.217 ЭМАХХ 1999/

⁴ Ужү Яотин Чингис хааны түүх шастир.УБ.,2002. хуудас 19

⁵ .А.Амар Монголын товч түүх. УБ1989 х157/

⁶ Ш.Нацагдорж.УБ 1978 Монголын феодализмын үндсэн замнал, хуудас60

1а Гадаад халхлалт



Энэ нь суурин иргэдийн хувьд аль нэг хот суурин газар стратегийн ач холбогдолтой байдаг бол нүүдэлчидийн хувьд нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо хамгаалах асуудал нь улс үндэстний аюулгүй байдал, хаан төрийн тогтвортой байдлын амин чухал ач холбогдол бүхий төрийн бодлого байдагтай холбоотой юм.

Үүнээс халх хэмээх өнөөгийн монголчуудын олонхи анхлан үүссэн учир шалтгаан харагдах бөгөөд халх гэдэг нэрийг судлаачид олон янзаар тайлбарладгаас эрдэмтэн Ж.Төмөрцэрэнгийн “халх гэдэг нь халхавч, халхлах гэсэн үгтэй язгуур нэгтэй бөгөөд ар өврийн дайснаас халхлах түмнээ ийнхүү нэрийддэг” гэсэнтэй тохирч байгаа юм.

Судлаачид ар өврийн дайснаас хамгаалан халхлах түмнээ халх гэж нэрийддэг гэх боловч “юунаас” “юуг” халхлах гээд байгааг сайн тодруулаагүй байдаг. Энэ нь түүхэн цаг үеүдэд өөрчлөгдөж ирсэн нь ойлгомжтой. Эхний үед шинэ гүрэн байгуулагдахдаа дагасан 61, дайчлан хураасан 24 \татар, тайчууд, горлос, хэрэйд, зүрчид, харлаг, найман зэрэг\ аймгуудаас⁷ бүрдсэн бөгөөд тэдний дотор төв засгаа дайсагнах шалтаг шалтгаан олон байсан нь тодорхой. Мөн эдгээр аймгуудыг өөрсдөө дагасан, хэлэлцэж дагасан, дайлж дагуулсан гэж ангилсан байдаг.

Эхний үед халхлах түмтэд жалайр аймаг голлосон байж болох юм. Халхын нэртэй холбоотой анхны түүхэн баримтад (жалайрын) Гоо ван Мухулай (prince of the state) Хангай нурууны хавиас халхын түмэн цэргийг байгуулж захирч байсан гэсэн бүдэг мэдээлэл байдаг. Мөн мянганы зохион байгуулалтаар гол түмнээ Чингис өөрөө авч, баруун, зүүн гараалтүмнээ\ Мухулай, Боорчи нарт өгсөн⁸ ч гэлцдэг

• Дэлхийд тэргүүлж байсан Өгөдэй, Гүег, Мөнх хааны үед Хар хорин хот хөгжин мандаж дэлхийн өнцөг булан бүрээс цугласан элч төлөөлөгч, худалдаачид хөлхсөн энэхүү хотоо тойрон монголын гол сурвалжит овог болох хиад нар Орхон Туулын бэлчир нутагтаа голлон төвлөрч байв. Чингис хааны дүү нарын хойчис Онон Хэрлэний дунд биед малжиж байв. Тэд оннигуд, авга зэрэг аймаг, отгийн нэртэй байж байгаад урагшилсан байдаг. Тэднээс үлдэгсэд Бэлгүтэйн удмын авгын тайж нар байдаг.

• Хубилай хаан төрсөн ах Аригбух болон Хайду, Наян нартай сөргөлдөн байлдаж байх үедээ Хархорин хот ялангуяа, сурвалжит “язгууртнууд–хиад”-уудад ихээхэн анхаарал тавьж, хүү Номхоноо тусгайлан томилж удирдуулж байжээ. Хэдийгээр Хубилай хаан Бээжинг нийслэлээ болгосон ч залгамжлах ханхүү Хархорин орчмыг захирч байж хаан сууринд суудаг, хаан ширээнд залрах төрийн ёслолоо Хархоринд хийж, цэргийн гол хүчнээ бэлтгэдэг зэрэг уламжлал, хүндэтгэлийн төв Хархорин хэвээр байж язгууртны гол угсааныхан энд төвлөрөн тусгай эрх ямба эдлэн, татвараас чөлөөлөгдөн оршин байв. Энэ үед Өгөдэйн ач хүү Хайдугийн угсааныхан ноёрхсон ойрадууд Ил тарвагатай орчимоос Цагадайнхны дэмжлэгтэйгээр энэ хавийг ноёрхохын төлөө өрсөлдөж байв.

• Бээжинд 100 гаруй жил сууршсан Хубилай хааны удмын хаад\1260 –1368\ торгон цэргийн хамт Бээжингээс хөөгдөж гарсан билээ. Чухам энэ үед дахин үүрэг, ач холбогдол нь нь нэмэгдсэн халх түмнийг магтан дуулахдаа:

Хангай ханд сууж- *Living in Hangai mountain*

Хариас ирэгсэддээ халхлагч болсон- *you are the guards those returning*

⁷ Инжаниш Хөх судрын үлгэр. Улаанбаатар, 1991 хуудас 157

⁸ Ш.Нацагдорж. УБ 1978 Монголын феодализмын үндсэн замнал, хуудас 60

Халуун амьдралд -Их хааны\ түшээ болсон Халх түмэн.⁹ *You are the support to the hot life (of the Khan). Halh Tumen*" гэжээ.

• Юань гүрний дараа буюу 40 түмэн монгол 4 түмэн ойрадаас бүрдсэн монгол гүрэнд хятадаас хөөгдсөн Толуйн удмын хаадын нэр хүнд, хүч нөлөө багасахын сацуу Аригбөх, Хайдугийн хойчисын нөлөөнд байсан ойрадын болон Хасарын удмын хорчин, горлос удмын ноёд, тайшууд \Адай, Тогон, Эсэн\ сэргэжээ.

Чухам энэ үе хамгийн ээдрээтэй цаг байжээ. Учир нь бага хаадын үеийн бутрал нь Хаан жонон хоёрын зөрчил, нөгөө талаар ойрадын тайш, хорчин нарын \Өгөөдэй, Хасарын удмынхнаас Толуйн удмын эсрэг гэж болно\ хаадын эсрэг хийсэн тэмцлээс үүдэлтэй. "...Ойрадын феодалууд Монголын хааны захиргаанд оршихыг хүсэхгүй ямагт тусгаарлах хөдөлгөөнийг гаргаж байсан учраас Зургаан түмэн улсуудын байрлал нь их төлөв ойрадуудын ар талаасаа довтлохын эсрэг чиглэгдсэн мэт байдаг"¹⁰ гэж түүхчид дүгнэжээ. Ойрадын тайшууд хаан, жонон хоёрын зөрчил дээр тоглож байр сууриа олох арга хайж, түүнийг нь Мин улс дэмжиж хаан, жонон ноёд нарт өөр өөр бэлэг өгөх зэргээр тэдгээрийн зөрчлийг дэвэргэхдээ гаргууд байжээ. Эцэст нь Чингис хааны дүү нарын хойчис оннигүд нар ойрадуудтай холбоотон байхаа больж Толуйн удмыг дахин дэмжсэнээр л 1455 оноос Тогта бух хааны хөвгүүд хаан сууринд сууцгааж ойрадуудыг баруун тийш нь буцаажээ.

Гадаадын аюул нь Мин улс байлаа. Энэхүү монголчуудын тэмцэл, зөрчилдөөнтэй байдал, засаг төрийн хямралыг ашиглан Мин улсын хаад стратегийн холын бодлоготойгоор Хар хорин хотыг газрын хөрстэй тэгшлэх, /туйнуу бүрийг эвдсэн гэдэг/ ойр орчимд амьдардаг язгуурын гол угсааг нь хядаж монголын голыг самрахаар Орхон Туулын бэлчирт довтлон ирж байсан учир хиадууд нүүдэлчдийн уламжлал ёсоороо Хангай нурууны ой, Саяны нурууны ард, Байгаль нуурын орчимд зугатан гарч аюулаас мултарч байв.

Эдгээр шалтгаанаар Тогоонтөмөр хаан Хархоринг нийслэлээ болгож, тэндээс монгол орноо удирдаж байх уламжлалаа сэргээх гэрээслэл үлдээсэн хэдий ч бага хаад /Аюушридар, Өлзийт Төмөр хаадаас бусад нь/ их говийн урд талд голдуу нүүдэллэж байв. Төрийн бодлогоор Бодь Алаг хаан цахаруудыг аван урагшаа нүүсэн гэдэг.

Ингэж бага хаад өвөр Монголд нутаглаж байсныг 1-т, халхын өндөрлөг, ялангуяа Орхон Туулын бэлчирээ хамгаалах гэсэн аюулгүй байдал, цэргийн стратегитай уялдсан төрийн бодлого 2-т, худалдааны замд хяналт тавих гэсэн эдийн засгийн эрх ашигтай холбон түүхчид тайлбарладаг. Мөн хаад арай илүү зөөлөн уур амьсгалыг эрхэмлэдэг байсан нь ойлгомжтой. Зүүн түмнийг /халх, цахар, урианхай/ хаан өөрөө удирдаж баруун түмнийг /ордос, түмэд, еншээбүү/ дүү нь буюу хүү жонон удирддаг байсан.¹¹

"Эдгээр "баруун", "зүүн" зургаан түмнээс урианхай нь худаг ухах, их цэргийн толгой сэргийлэх, Ордос түмэн Чингисийн онгоныг сахих, Түмэд нь Алтайн 12 сүвийг хаах¹² зориулттай байв. Юншээбүү-хорчин түмэн нь тарагчин, айрагчин буюу хорчин-хишигтэн нум сумчдаас, харчин түмэд нь мал малладаг айраг исгэдэг малчдаас бүрдсэн түмдүүд байжээ. Товчхондоо эдгээрийг "үйлчлэх түмэд" гэлтэй.

Цахар түмэн нь бага хаадын хувийн аймаг, хааны шадар хишигтэн -хамгаалагчид байв. XVI зууны үед аймаг, отог, ястан угсаатангуудыг холилдуулан нэг үндэстэн бүрэлдүүлэх үйл ажиллагааг төрийн хатуу бодлогоор гүйцэлдээсний түүхэн үр дүнд цахарууд бий болжээ. Халх, цахарууд "халхлах хамгаалах" түмэд гэлтэй. Дээрх 6 түмэд угсаатны хувьд нилээд олон овог, угсаатны нэгдэл байсан бололтой.

Эдгээр "баруун", "зүүн" 6 түмэн "үйлчлэх, халхлах хамгаалах" зорилготой юм бол "Манай сурвалж бичгүүдэд төвийн түмэн, хаа байсан ба түүнийг хэн толгойлж байсан тухай өгүүлэхгүй байна. ..." ¹³ гэсэн асуулт аргагүй төрөх нь ойлгомжтой.

Халхын Дүүрэн төмөр хунтайж, халхын Ажаа тайжийн хүүд Тайсун Тогтабух, Мандуул нар хаан болж, Агваржин жонон, халхын Хархурцаг тайж нараас Батмөнх Даян хаан төрж байснаас харахад "... Тэд ...онцгой байр суурийг эзэлж, хааны отгон хүүгийн

⁹ Чингисийн их тахилгын өчиг, Монголын 6 түмний магтвал, Дамдинсүрэн 1952: 63;


¹⁰ Монгол Улсын Түүх, 2003, УБ., гутгаар дэвтэр хуудас 121

¹¹ МУТ, 2003, Улаанбаатар, 3-р боть, хуудас 121

¹² Монголын түүх\Ш. Лувсандорж 2001 хуудас 152 \

¹³ Ш.Нацагдорж, Улаан баатар 1978 Монголын феодализмын үндсэн замнал, хуудас 144, МУТ, 2003, Улаанбаатар, 3-р боть, хуудас 121

захиргаанд оршиж байсан бололтой. ..."¹⁴ гэсэн түүхчид асуултын хариулт буюу хаад цахараар хамгаалуулж, голдуу говийн урдуур нутаглаж байсан тул жононгууд эсхүл хаадын отгон болон залгамжлах хүүд хойд талдаа "халх"-ын гэсэн тодотголтойгоор төвийн түмнээ удирдаж дараагийн хаадыг төрүүлж байсныг харуулж байна. Зураг№3




¹⁴ Ш.Нацагдорж. Улаан баатар 1978 Монголын феодализмын үндсэн замнал, хуудас 144, МУТ, 2003, Улаанбаатар, 3-р боть, хуудас 121

Эцэст нь халхууд Их хаадын язгуур төрийн голлох төв хэсэг-хиадын нутгийг хамгаалах үүрэгтэй байсан бол цахарууд ойрад, монголын зөрчлийг дараах үед бага хаадыг хамгаалах хишигтний, цаашилбал халх монголын өндөрлөгийг урд талаас манж хятадаас халхлах төр, цагийн бодлогын хэлхээс байжээ гэсэн дүгнэлт хийж болно.


Батмөнх Даян хаан дотоодын олон отог, овгийн зөрчилдөөнөөс болж ихээхэн зүдэрсэн хүний хувьд нэгдүгээрт нутгийн төв хэсэг, гол уугуул овог, отгоо халхлан хамгаалах нүүдэлчдийн төрийн бодлогыг сэргээснээр төрөө төвхнүүлж чаджээ. Хоёрдугаарт "сүүлчийн могокан" болохоо дөхсөн гашуун туршлагадаа үндэслэн /Халхын Харгуцаг тайж-Эсэн тайжийн охин хатан Цэцэг нарын хүү тэрбээр ойрадын "Боржигины үрийг таслах" үйлээс - /азаар амьд үлдсэн 11 хүүдүүдээрээ монголын бүх зонхилох аймаг хошуудыг удирдуулан боржигин удмаар монголын бүх язгууртнуудын угийн эхэнд тавих бодлогыг эхлүүлжээ. Батмөнх даян хааны угсааныхан өөрсдийгөө дан боржигин овогтой хэмээх болжээ.

Тэрээр Орхон, Туулийн бэлчирт нүүдлэгч Их хүрээ, хаадын өргөө, язгуур хиадуудын аюулгүй байдлыг гаднаас Мин улсаас хамгаалах төдийгүй дотоод талаасаа буюу халх, ойрадын зөрчлөөс үүдэж ойрадуудаас "халхлан" зорилгоор Хангай нурууны ард, Хөвсгөл, Хэнтий нурууны хавьд шинээр аймгуудыг байрлуулжээ. Зураг №2а.б

2а Гадаад халхлалт Батмөнх Даян хааны үед



2б Дотоод халхлалт



Энэ удаа жалайрууд төдийгүй бэсүд, олхонуд, тангуд-сартуул, хиргис, элжигин, горлос, үнэгэд, хэргүд, хүрээ, цоохор, хөхүйд, хатахин нарыг хуваарилажээ. Учир нь жалайрчуудыг Орхон Туулын бэлчирьг Хангай талаас халхалж тусгай эрх ямбатай он удаан жил байлгасан нь тэдний ноёд эрх, мэдлээ хэтрүүлэхэд хүргэсэн бололтой.

Батмөнх Даян хаан 11 хүүдээ нутаг заан захируулахдаа хүү Гэрболдодоо ар халхын 7 түмнийг өгчээ. Гэрболдыг буюу хааны үрс аймаг хошуу болгоныг захирах бодлогыг жалайрын ноёд эсэргүүцсэн тул түүнийг өөр хүү Гэрсэнзээр түүнийг сольж дэг журам тогтоож байсан.¹⁵ Гэрсэнзийн хөвгүүд болох Ашихайд-үнэгэд, жалайр, хүү Ноёнтойд –бэсүд илжигин, Далдайд –Тангуд, сартуул, Самубумад–урианхан отгийг тус тус өвлөн өгснөөр баруун гар болгож баруун талаа\Засагт ханы эхлэл\, мөн Амин Дуралд–хүрээ хороо, цоохор, Дарьд –хүхүйд, хатагиныг өгснөөр зүүн\Цэцэн ханы эхлэл\, болон хойд талаа тус тус халхлалтад авчээ.¹⁶

Өвөр халх 5 түмнийг /баягуд, үжигэд, жарууд, баарин, хонхирад/ Мин улсын явуулгаар ихэд суларсан урианхайн 3 халх түмний үлдэгдэл болон хорчингуудын хүчийг сэлбэн Монголын өндөрлөгийг зүүн урд талаас халхлуулах зорилгоор Хянганыг давж нүүлгэжээ. Ингэж монголын төв–хиадууд зүүн урд тал, баруун талаасаа шинэ халхлах аймгуудтай болохын сацуу Алтайн 12 сүвийг хаах¹⁷ зориулттай Түмэд болон өвөр монголын урд талын халхлалтаа шинэ хүчээр бэхжүүлжээ.

Гэрсэнзийн 7 хүүдүүд дахин зохион байгуулагдсан халхын 7 отог, хошууг захирах болсноос төв отгийг нь Оноход өгчээ.

Гэх мэтчилэн тэд хүүхдүүддээ үргэлжлүүлэн хувааж өгсөөр байгаад халхын зуу орчим хошуу /86/ бий болжээ. Ингэж халхын удмын тайж нарыг бүрэлдүүлэгч ижил эрх

¹⁵ Алтан товч(Лувсандамдин 1990: 187).

¹⁶ Гонгор, Д. Халх товчоон 1–р дэвтэр, ШУАХ, УБ. 1970. х–177

¹⁷ Монголын түүх\Ш.Лувсандорж 2001 хуудас 152 \

мэдэл, гарал сурвалжтай олон ноёд, язгууртнууд халхын 4 хан болон бүх хошуудад бий болсноор хиадуудын үүрэг роль багасчээ. Эдгээр тайж нар сүүлийн 300 гаруй жил ихэд жижгэрсэн өөрсдийн хошууныхаа иргэдийг хамжлагаа болгон хөдөлгөөнийг нь хязгаарлаж, өөрсдөө тэдэнтэйгээ хамт манжийн хааны татварт дарагдсан билээ. Үр дүнд нь халхын бүх хошуудад боржигин овог жигд тархаж халхыг бүрэлдүүлэгч олон овог, отог угсаатны хувьд ижилсэж ойртжээ. Эдгээр тайж нар өөрсдөө ч хамжлага иргэдтэйгээ холилдсон. Нэг хошуудын иргэдийн 20–30 хувь нь тайж нартай ураг барилддаг.¹⁸

Ийм учраас халхын хошууд хил хязгаартай болж нүүдлэх нь хязгаарлагдсан болон бүх хошуудад Даян хааны удмынхан буюу боржигин овог жигд тархаснаар¹⁹ халхыг бүрэлдүүлэгч олон овог, отог угсаатны хувьд ижилсэж ойртжээ. Ингэснээр гол язгууртнууд төвлөрч байсан хиадууд болон бусад халх хошуудын угсаа, эрх ямба, эдийн засгийн байдал адилхан болсноор хиадын гол язгуурын нутаг хошууны эрх, үүрэг бүдгэрч багасан улмаар “халх” хэмээх орчин үеийн монгол үндэстнийг бүрдүүлэгч гол угсаатан төрөх үндсэн нөхцөл болжээ гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ингэж “халх” гэсэн үг монголчуудын гол угсаатны жинхэнэ нэр болон хэлбэржин тогтсон бөгөөд Батмөнх Даян хаан, Гэрсэнз, Абтай сайн хаан нарын үүрэг их байжээ. Ингэж “халх түмэн” явсаар халх монгол хэмээх шинэ үндэстэн бүрэлдэн бий болсон талаарх түүхэн баримтууд Гонгор гуайн номонд²⁰ дэлгэрэнгүй байдаг. Гэхдээ халх овог гэж байсан байж болох тухай хэсэг нь төдийлөн баталгаатай биш болов уу.

XX зуун ба халх хиадууд

Янз бүрийн цаг үед олон төрлийн нөхцөл байдлын дунд үүссэн халхын доторхи олон яс угсаатнууд өнөөдөр ч онцлогоо хадгалан Орхон Туулын бэлчирээ “**тойрон**” тодорхой газар нутагт амьдарсаар байгааг 2002 онд А.Очирын “Халхын арын долоон отгийнхны угсаатны бүрэлдэхүүн, гарал, тархац” судалгаа нийтлэлд тодорхой тусгагджээ. Халхыг бүрдүүлэгч жалайр, бэсүд, олхонуд, тангуд-сартуул, хиргис, элжигин, горлос, үнэгэд, хэргүд, хүрээ, цоохор, хөхүйд, хатахин зэрэг отог хошуудын өнөөгийн байрлалыг тодорхойлсон нь Батмөнх Даян хаан 1492-1502 оны үед хийсэн “халхлах” хуваарлалттай тохирч байгаа юм.²¹ Харин энэ номонд хиадуудыг яс, угсаа, отог гэж огт дурдаагүй байдаг.

2000 оны зааг дээрх овог сэргээх “кампанит” ажилтай холбогдуулан 1918, 1924 оны хүн амын тооллого, манжийн эр цэргийн бүртгэл, намын 1,2,3-р их цэвэрлэгээний архивын материалд түшиглэсэн овог угсаатны судалгаагаар²² **хиад** овог нь зөвхөн Өвөрхангай аймгийн хуучин Түшээт хан аймагт харьяалагдаж байсан зүүн хойд талын \Хархорин, Бүрд, Баян-өндөр, Зүйл, Өлзийт, Сант хуучнаар Түшээт ханы болон Далайгүний хошууд\ Төв аймгийн баруун талын дөрвөн сум \Дэлгэрхаан, Өндөрширээт Эрдэнсант, Бүрэн-Цэцэн вангийн болон Зоригт вангийн, Үйзэн гүнгийн хошууд\, Булган аймгийн Орхон голын урд талын сумд Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Хишиг-өндөр гэх мэт хэдэн суманд л байдаг. Архангайн Батцэнгэл суманд хиад боржигин гэсэн овог байдаг бол хиа нар гэсэн овог зарим газар мэр сэр тааралддаг. **Мөн** тавд, гүжир овгууд энэ хавийн сумдад л байдаг ажээ.

¹⁸ Хиадууд ба Дэлгэрхааныхан Ч.Сосорбарам. 2003 Улаанбаатар, хуудас 20

¹⁹ Боржигин овог үгүй хошуу сум ар, өөрийн халхуудад байхгүй байсан бөгөөд урианхай, харнууд шарнууд зэрэг бусад олон овгийн адил өнөөдрийн халхын бүх сумдад тархаж ялгаж салгахад хэцүү болжээ.

²⁰ Гонгор. Д. Халх товчоон 1–р дэвтэр, ШУАХ, УБ. 1970. х–137

²¹ Төв азийн нүүдэлчдын угсаатны түүхийн асуудал. Улаанбаатар. 2002 Нүүдлийн соёл иргэншил судлах олон улсын хүрээлэн”

²² О.Сэржээ Улаанбаатар, 1998 он, Ургийн судалгаа...хуудас 14, 30, 38

Зураг№3а.б.в

Зураг№3а



Ингэж хэдийгээр дайн мөргөлдөөний хөлд 1-т, Мин улсын цэрэг, 2-т, Галдан бошигтын довтолгооны үед нэрвэгдэж байсан ч хиадууд буюу монголын гол сурвалжтаны угсаа Орхон Туулын бэлчирт үргэлжлэн нутагласаар ардын хувьсгалтай золгосон юм.

Чингис хааны төрөл төрөгсөд язгуурын овог зонхилон хаана амьдарч, ямар үүрэгтэй байсан нь нүүдэлчдийн төрийн нууцтай холбоотой байснаас манай түүхэн баримт бичгүүдэд хиадуудын талаар шууд ил гаргаж бичдэггүй хэдий ч:

–Чингис хааны отгон хүү Толуй Орхон, Туулд байж хүүд нь их хаад болсон, Хубилай хааны үед хан хүүд онцгойлон Хархорин хавийг захирдаг байсан, халхыг захирч байсан Дүүрэн төмөр хунтайж, Ажаа тайж нарын удам болох Тайсун, Мандуул нар тасрах шахсан бага хаадын аргамжааг үргэлжлүүлсэн бөгөөд халхын Хархурцаг тайжийн удам Батмөнх Даян хаан, энэ аргамжааг таслаагүй сэргээснээр түүний удам Гэрсэнэ, Онох, түүний хүү Автай сайн хаан, Түшээт ханууд уламжлан монголын нутгийн төв хэсэг гол уугуул овог, отог (гал голомт)–ийг хариуцаж ирсэн түүх..

Хошуудын зураг



Эдгээр хиад нарын хошууд, сумд нь баруун, хойд талаараа Орхон голоор хүрээлэгдэж, зүүн талаараа Туул голоор эмжэгдэн тохойрсон уул ус, тал хээр жигдхэн үзэсгэлэнтэй сайхан билчирт байдаг Хөгнөхаан, Батхаан, Дэлгэрхаан уулуудыг тойрч адуу ихтэй, айраг исгэж алдартай. Хошууд хойноосоо урагшаа сунасан байрлалтай, хангай, хээр, говь хосолсон нутаг байв

Булган

Бишрэлт гүний 84

Жонон гүний тал 85

Үйзэн гүний 83

Өвөрхангай

Түшээт Ханы 81

Далай гүнийн 82

Төв

Сэцэн вангийн 80

Зоригт вангийн 79

Дээр дурдсанаар монголын аймаг, хошуудын байрлал гол хэсгээ хамгаалах зорилгоор цаг үргэлж өөрчлөгдөн байршиж байсан байдал,

Мөн төвийн хэсэг буюу халх түмэн харьцангуй бие даасан байдал. .

Орхон Туулын бэлчир нутагт монголын бусад бие даасан овог, отог, аймгуудыг XII зуунаас хойш нутаглуулж байгаагүй баримт,

Дээр нь овог угсаатны нарийвчилсан судалгаагаар²³ монголын язгуур хиад овог/яс\ нь зөвхөн Орхон Туулын билчир нутагт байгаа зэрэг нь XIII зуунаас өнөөг хүртэл хиадууд тодорхой газар нутагт оршоор ирснийг харуулж байна. Хиад овгийг "овог" гэх үү "овгийн улбаа" эсхүл "яс" гэх үү гэдгийг л судалж тодотгох мөн хиян, хиад, хиягуд, хиа нар гэсэн үгийн үндсийг сайтар харьцуулан судлах нь зүйтэй гэж үзэж болно.

Ер нь хиад угсаатны өнөөгийн байдал нь "мэдээжийн юмыг яах вэ" гэсээр байгаад асуудлыг тодорхойгүй болгогчийн сонгодог жишээ биз ээ. Нөгөө талаас түүхчид монголын төрийн тухай судлахдаа хаадын тухай өгүүлэхээс хааны төрөл төрөгсөд язгуурын овог зонхилон хаана амьдарч, ямар үүрэгтэй байсныг төдийлөн гаргаж тавьдаггүй нь энэ асуудал нүүдэлчдийн төрийн нууц байдагтай ч холбоотой байсан байж болох юм. Ийм учраас сүүлийн үед "Манай сурвалж бичгүүдэд төвийн түмэн, хаа байсан ба түүнийг хэн толгойлж байсан тухай өгүүлэхгүй байна. Тэд ...онцгой байр суурийг эзэлж, хааны отгон хүүгийн захиргаанд оршиж байсан бололтой. ..." ²⁴ гэж түүхчид үзэх болжээ.

Abstract:

Mongolia is now embroiled in a myriad social problems. Mongolian scholars have suggested that Mongolia has been able to foster a homogeneous nationality; but in a time of market economy and freedom, various groups openly- desire to express their ethnicity. Mongolia is a multi-ethnic state. The population includes several ethnic groups of Mongolian origin and some Turkic origin. This article will not deal in detail with the numerous small groups of ethnicity. Instead, it attempts to answer one question who is "hiad" ethnic group, how it related with "halkh" or mongolian "main ethnic group-nation" and it is still existing or not.

In order to reach one clear connotation on a word "khalkh," which has been interpreted differently by historians and researchers, Western study of Mongolian ethnicity- is limited. Many mongolian historians and scholars have attempted to invent a history presenting the halkh as the most important group of Mongols from the inception of to Mongol nation. They like to tell that three-river region (the drainage area of the Orhon, Herlen, and Tuul) which is the ancestral land of Mongols ruled by- Tolui was then called *Goliin Uls* (core or central nation), as mentioned in the *Secret History*(section 269). Gongor (1970: 138) seems to suggest that halkh were the principal group which inhabited the Mongol homeland. But others

²³ О.Сэржээ Улаанбаатар, 1998 он, Ургийн судалгаа...хуудас 14, 30, 38, Төрийн захиалгаар, ШУА, төслөөр хийгдсэн

²⁴ Ш.Нацагдорж.УБ 1978 Монголын феодализмын үндсэн замнал, хуудас 144, МУТ, 2003, УБ 3-р боть, х-121

as Okada (1993: 189) and Urad Bulag comment Ordos-Tsahar Tumen was only one of the Mongol groups that once lived in the heart of the Mongol homeland. These lines indicate that the halkh were not the central tribe, but a supporting one which provided protection to Batmonh Dayan Khan against the western wing as well as the Oirat –Mongols. A hierarchization of Mongolian groups by ethnicity has lasted during last century.

In my view, both a version of central tribe is not fully correct because they could not evidently studied about historical role of the hiad group who was key element for link between all Mongol groups.

I would like to promote one of my findings during study in my native land in this article. "Khalkh" term was initially used to name the group of *tumen* (administrative unit, comprising ten thousand people) in charge of guarding king and his 'khiad' the core part of kingdom and later it became a given name of one major ethnic group in Mongolia.

As an historic result of implementation of the state strict policy on assimilation and unification of provinces, tribes as well as ethnic groups in the 12 and 16th centuries, ethnic groups such as "khalkh" and 'tsahar' were created. "Khalkh" and "tsahar" were explained as "guard and protection" *tumen*.

It is clear that the following questions should be raised. If these 6 '*tumen*' were tasked "to serve, guard and protect," where central *tumen* was located and who were leaders of the central *tumen*...'

Эшлэл:

1. А.Амар Монголын товч түүх. УБ 1989
2. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал УБ 1978
3. Инжаниш Хөх судрын үлгэр. Улаанбаатар, 1991.
4. Дамдинсүрэн Чингисийн их тахилгын өчиг, Монголын 6 түмний магтаал. 1952: 63;
5. МУТ, 3–р боть. Улаанбаатар, 2003,
6. Ш.Лувсандорж Монголын түүх, Улаанбаатар, 2001.
7. Лувсандамдин Алтан товч Улаанбаатар, 1990.
8. Д. Гонгор. Халх товчоон 1–р дэвтэр, ШУАХ, УБ. 1970.
9. Нүүдлийн соёл иргэншил судлах олон улсын хүрээлэн. "Төв азийн нүүдэлчдийн угсаатны түүхийн асуудал" Улаанбаатар. 2002,
10. О.Сэржээ Ургийн судалгаа... Улаанбаатар, 1998,
11. Сборник летописей. т. к № д М-Л, 1952,
12. Жү Яотин Чингис хааны түүх шастир. Улаанбаатар. 2002. хуудас 19
13. Урадийн.Е.Булаг. "Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзүүд". Кларендон хэвлэл. Охфорд. 1998.
14. Б.Онхоон. "Төв аймгийн Дэлгэр хаан сумын өвгөд, дээдэс, эдүгээ үеийнхний түүхээс түүх" Улаанбаатар. 2001
15. Ч.Сосорбарам. Хиалууд ба Дэлгэрхааныхан. Улаанбаатар. 2003.